



МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ТОГТООЛ

2005 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 66

Улаанбаатар хот

Журмын шинэчилсэн найруулгыг батлах тухай.

"Компанийн тухай хууль"-ийн 2 дугаар зүйлийн 4, "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 10, 11, 21, 66 дугаар зүйлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх түр журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ журмыг "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль" болон холбогдох бусад хуульд өөрчлөлт орох хүртэл хугацаанд үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллахыг Төрийн өмчийн хорооны газар, мэргэжилтэнүүд, төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй нийт бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.
3. Энэхүү шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн хорооны 2000 оны 576 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх түр журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

Дарга

Дарга

М.М

З ЭНХБОЛД

Захиргаа, удирдлагын
гаарын дарга

Л.АРИУНАА



ТӨХ-ны 2005 оны 66
дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТӨРИЙН ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТҮР ЖУРАМ

Нэг Нийтлэг зүйл

- 1.1. "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай" хууль, "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 10 дугаар зүйл, 11 дүгээр зүйлийн 1,2,3,5,6 дахь хэсэг, 18, 21 дүгээр зүйлийг удирдлага болгон Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх арга хэлбэр, төрийн өмчийн төлөөлөгчдийн ажиллах зарчим, эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх чиг үүргийг Төрийн Өмчийн Хороо /ТӨХ/ гүйцэтгэнэ.
- 1.3. Энэхүү журамд товчилсон нэрнүүдийг дор дурдсанаар ойлгож хэрэглэнэ.

ТӨХ-Төрийн Өмчийн Хороо

ТӨҮХГ-Төрийн өмчийн удирдлага, хувьчлалын газар

ТӨХБХЗГ-Төрийн өмчийн хяналт, бүртгэл, хангамж зохицуулалтын газар

ЗҮГ- Захиргаа, удирдлагын газар

ТӨЗ-Төлөөлөн удирдах зөвлөл

УЗ-Удирдлагын зөвлөл

ХШХ-Хянан шалгах зөвлөл

ТӨҮГ-Төрийн өмчит үйлдвэрийн газар

Хоёр. Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх хэлбэр

- 2.1. Төрийн өмчийн төлөөллийг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ,
 - 2.1.1 Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Хувь нийлүүлэгчдийн хуралд таслах эрхтэй төлөөлөгч томилон оролцуулах,
 - 2.1.2 Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн өмчийн оролцоотой хувь тэнцүүлэн төрийн өмчийн төлөөлөгч томилон ажиллуулах,
 - 2.1.3 Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Хянан шалгах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн өмчийн оролцоотой хувь тэнцүүлэн төрийн өмчийн төлөөлөгч томилон ажиллуулах.

- 2.1.4 Төрийн өмчит үйлдвэрийн газарт шаардлагатай гэж үзвэл Удирдлагын зөвлөл байгуулж дарга, гишүүдийг томилон ажиллуулах.
- 2.1.5 Төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захиралтай үр дунгийн гэрээ байгуулах,
- 2.1.6 Төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлыг томилон ажиллуулах,
- 2.1.7 Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ дүгнэлт өгөх, хяналт шалгалт хийх.

Гурав. Төрийн өмчийн төлөөллийг томилох

- 3.1 Төрийн өмчийн хорооны Төрийн өмчийн удирдлага, хувьчлалын газар /ТӨҮХГ/ нь төрийн өмчийн төлөөлөгчийг томилуулах, өөрчлөх санал боловсруулж Хорооны хурлаар шийдвэрлүүлэх, тэдний үйл ажиллагаанд хяналт тавих, арга зүйн удирдлагаар хангах, туслах ажлыг хариуцна.
- 3.2 Төрийн өмчийн төлөөлөгч гэж төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл /ТҮЗ/, Хянан шалгах зөвлөл /ХШЗ/, Удирдлагын зөвлөл /УЗ/ -д төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэхээр Төрийн өмчийн хорооны шийдвэрээр томилогдсон дарга, гишүүдийг хэлнэ.
- 3.3 Төрийн өмчийн аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газарт шаардлагатай гэж үзвэл Төрийн өмчийн хорооны шийдвэрээр Удирдлагын зөвлөл байгуулан ажиллуулж болно. Энэ талаар тухайн хуулийн этгээдийн дүрмэнд заавал тусгасан байна. Удирдлагын зөвлөлийн ажиллах журам, эрх хэмжээ, жилийн зардлын төсвийг ТӨХ батална.
- 3.4 Төрийн өмчийн төлөөллийн бүрэлдэхүүнд ТӨХ-ны дарга, гишүүд, ТӨХ-ны газрын дарга, мэргэжилтэн болон төрийн захиргааны байгууллагын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг томилон ажиллуулна.
- 3.5 Төрийн өмч давамгайлсан компанийн ТҮЗ, ХШЗ-ийн даргад Төрийн өмчийн хорооны шийдвэрээр нэр давшүүлнэ.
- 3.6 Төрийн өмчийн төлөөлөгчийг томилох саналыг Төрийн өмчийн удирдлага, хувьчлалын газар боловсруулж Хорооны хуралд оруулан шийдвэрлүүлнэ. Төрийн захиргааны төв байгууллагад ажилладаг албан хаагчийг төрийн өмчийн төлөөлөгчөөр ажиллуулах санал гаргахдаа тухайн байгууллагын саналыг авсан байна.

Дөрөв. Төрийн өмчийн төлөөлөгчийн ажиллах удирдамж

- 4.1 Төрийн өмчийн төлөөлөгч нь төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэхдээ "Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай" хууль, "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хууль,

"Компанийн тухай" хууль, бусад хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэр, Төрийн Өмчийн Хорооны шийдвэр, энэхүү журам, териийн өмчит болон териийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дурэм, ТҮЗ, ХШЗ, УЗ-ийн ажиллах журам, ТӨҮХГ-аас боловсруулж, ТӨХ-ны даргаар батлуулсан териийн өмчийн төлөөлөгчийн ажиллах удирдамжыг мөрдлөг болгоно.

Энэхүү журмын 2.1.7-д заасан хяналт шалгалтын ажлын удирдамж, графикийт ТӨХБХЗГ-ын саналыг үндэслэн ТӨХ-ны дарга батална.

- 4.2 Энэхүү журмын 6.4 дүгээр зүйлд зааснаас бусад асуудлаар ТҮЗ, УЗ, ХШЗ-ийн хурлаас гаргах шийдвэрийн тухай удирдамжийг ТӨҮХГ-ын дарга батална. ТҮЗ, УЗ, ХШЗ-ийн дарга нь Хорооны газрын дарга байвал удирдамжаа ТӨХ-ны даргаар батлуулна. ТҮЗ, УЗ-ийн дарга нь ТӨХ-ны дарга бол өөрөө хурлаа удирдаж байгаа тохиолдолд удирдамж авах шаардлагагүй.
- 4.3 Төрийн захиргааны төв байгууллагад ажилладаг териийн өмчийн төлөөлөгч нь шаардлагатай гэж үзвэл ТҮЗ, ХШЗ, УЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлаар Төрийн захиргааны төв байгууллагын сайд, даргын саналыг Хороонд бичгээр ирүүлж удирдамж батлахад уг асуудлыг тусгуулж болно.
- 4.4 Удирдамжийг териийн өмчийн төлөөлөгч нарт хурал хуралдахаас өмне хүргүүлэн танилцуулсан байна.
- 4.5 Төрийн өмчийн төлөөлөгч нар өгсөн удирдамжийн дагуу ТҮЗ, УЗ, ХШЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлаар гаргах шийдвэрийн төслийг боловсруулан бодлого чиглэлээ үрьдчилан нэгтгэж шийдвэр гаргахад нэгдмэл саналтай нэг субъект байна.
- 4.6 Удирдамжид тусгагдсанаас өөр саналтай төлөөлөгч нь хурлаас өмне өөрийн саналын үндэслэл, тооцоо, судалгаа хуулийн заалтыг тусгасан тайлбараа ТӨҮХГ-т бичгээр өгнө. Уг саналыг Хорооны даргад танилцуулж шаардлагатай бол шинээр удирдамж өгч болно. Энэхүү удирдамжийг Хорооны дарга батлах бөгөөд түүнийг төлөөлөгч нар мөрднө.
- 4.7 Төлөөлөн удирдах зөвлөл, Удирдах зөвлөл, Хянан шалгах зөвлөлд териийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй төлөөлөгчдөд териийн өмчит болон териийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн эцсийн ажлын үр дүнгээр урамшуулалт олгох асуудлыг ТҮЗ, УЗ-ийн хурлаар хэлэлцэн, ТӨХ-ны хурлаар шийдвэрлүүлнэ.
- 4.8 Энэ журмын териийн өмчийн төлөөлөгчтэй холбоотой нийтлэг заалтууд нь Хянан шалгах зөвлөлд териийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд нэгэн адил хамаарна.

**Тав. Хувь нийлүүлэгчдийн хуралд
терийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх**

- 5.1 Териийн өмчит болон териийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Хувь нийлүүлэгчдийн хуралд таслах эрхтэй оролцох териийн өмчийн төлөөлөгчийг Хорооны шийдвэрээр томилж удирдамжийг батлан, итгэмжлэл олгоно. Энэхүү журмын 6.4-д зааснаас бусад асуудлыг

хэлэлцэхэд Терийн өмчийн хорооны даргын тушаал гаргаж итгэмжлэл олгоно.

- 5.2 Терийн өмчийг төлөөлж буй бусад гишүүд хуралд зөвлөх эрхтэй оролцож болно.
- 5.3 Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь батлагдсан удирдамжийн дагуу ажиллаж хууль, дүрмийн дагуу саналаа гаргаж, итгэмжлэлээ хавсарган өгнө.
- 5.4 Удирдамжид өөреөр заагаагүй бол энэ журмын 5.4-д зааснаас бусад асуудлаар санал хураахад итгэмжлэгдсэн төлөөлөгч нь хууль тогтоомжид нийцүүлэн санал өгөх эрхтэй.
- 5.5 Хурлын явцад удирдамжид заагаагүй асуудлаар Хувь нийлүүлэгчдээс гаргасан саналыг тухайн үед шийдвэрлээгүй нехцөлд тодорхой хэмжээгээр цаг хугацаа алдсанаас эд хөрөнгийн хохирол хүлээх, илүү зардал гаргахаар бол Хорооны удирдлагатай холбоо барьж, амаар тодорхой удирдамж чиглэл авсны дагуу санал өгч болно. Харин уг удирдамжийг хурлын дараа бичгээр баталгаажуулна.
Энд зааснаар удирдамж авах боломжгүй нехцөлд итгэмжлэгдсэн төлөөлөгч нь энэ журмын 5.4-д заасныг баримтлан саналаа өгнө.
- 5.6 Эчнээс санал хураалтаар компанийн Хувь нийлүүлэгчдийн шийдвэр гаргахаар тогтсон нехцөлд хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төслийг Хорооны хурлаар хэлэлцүүлэн удирдамж авсны үндсэн дээр Терийн өмчийн удирдлага, хувьчлалын газрын дарга албан бичгээр санал өгч, саналын хуудсанд Хорооны тэмдэг дарна.
- 5.7 Терийн өмчийн төлөөлөгч нь Хувь нийлүүлэгчдийн хурлын баримт бичгийг салбар хариуцсан мэргэжилтэнд хурал хуралдахаас ажлын 21-ээс доошгүй хоногийн өмнө өгнө. Уг мэргэжилтэн хурлын удирдамжийг боловсруулан Хорооны хуралд оруулан шийдвэр гаргуулна.
- 5.8 Терийн Өмчийн Хороо шаардлагатай гэж үзвэл Хувь нийлүүлэгчдийн эзлжит бус хурлыг зарлан хуралдуулах удирдамжийг териийн өмчийн төлөөлөгч нарт өгнө.
- 5.9 Хувь нийлүүлэгчдийн хурлын тооллогын комисст Хянан шалгах зөвлөлд териийн өмчийг төлөөлж буй гишүүн заавал орно.
- 5.10 Хувь нийлүүлэгчдийн хуралд териийн өмчийг төлөөлж таслах эрхтэй оролцсон териийн өмчийн төлөөлөгч нь ТӨҮХГ-т Хувь нийлүүлэгчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр болон удирдамжийг хэрхэн биелүүлсэн талаар тайлангаа бичиж хүлээлгэн өгнө. Энэхүү тайланг ТӨҮХГ Хорооны хуралд оруулан хэлэлцүүлж дүгнэлт гаргуулна.
- 5.11 Териийн өмчит болон териийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ХШЗ-д териийн өмчийг төлөөлж буй гишүүн нь Хувь нийлүүлэгчдийн хуралд компанийн удирдлагын үйл ажиллагас болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах ба Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийн биелэлтэд хяналт тавина.

Зургаа. Төлөөлөн удирдах зөвлөл, Хянан шалгах зөвлөл, Удирдлагын зөвлөлд териийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх

- 6.1 Терийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ТУЗ, ХШЗ-ийн бүрэлдэхүүнд Терийн өмчийн хорооны шийдвэрээр томилогдсон терийн өмчийн төлөөлөгчид ажилана.
- 6.2 Тухайн хуулийн этгээдийн ТУЗ, УЗ-д терийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй төлөөлөгчдийг терийн өмчийн төлөөллийн бүрэлдэхүүн гэнэ. Терийн өмчийн төлөөллийн бүрэлдэхүүн нь энэ журманц зассан асуудал боловсруулах, удирдамж авах, тайлагнах, хянах зэрэг, асуудлыг ТУЗ, УЗ-ийн нарийн бичгийн даргад хариуцуулан ТУЗ, УЗ-ийн ажиллах журамд заавал тусгана.
- 6.3 ТУЗ, УЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой танилцуулга, тооцоо, судалгааг ТУЗ, УЗ-ийн нарийн бичгийн дарга нь терийн өмчийн төлөөллийн уг асуудлыг хариуцсан төлөөлөгчтэй зөвшилцэн боловсруулж ТӨҮХГ-т хурал хуралдахаас ажлын 14 хоногийн өмнө өгнө. ТӨҮХГ нь удирдамжийн теслийг боловсруулж, ТӨХ-ны дарга, эсвэл ТӨХ-ноос эрх олгосоны дагуу ТӨҮХГ-ын даргаар батлуулан хурал хуралдахаас ажлын 3 хоногийн өмнө терийн өмчийн төлөөлөгчид өгнө.
- 6.4 Дараахь асуудлыг ТУЗ, УЗ-ийн хурлаар хэлэлцэхэд заавал ТӨХ-ны хуралд оруулж удирдамж авна.
- 6.4.1 Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт
 - 6.4.2 Их хэмжээний хэлцэлд хамаарах асуудал
 - 6.4.3 Терийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, ТӨҮГ-ын захирлыг томилох, чөлөөлөх
 - 6.4.4 Гүйцэтгэх захирал, захиралтай байгуулах үр дүнгийн гэрээний зорилтот түвшинг тогтоох
 - 6.4.5 Гүйцэтгэх захирал, захиралтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх, шагнал урамшуулал олгох, хариуцлага хүлээлгэх
 - 6.4.6 Бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө оруулалт хийх, үндсэн хөрөнгө данснаас хасах
 - 6.4.7 Терийн өмчийн эзэмшлийн хувь хэмжээнд өөрчлөлт оруулах
 - 6.4.8 Ногдол ашгийн хувь хэмжээ тогтоох
 - 6.4.9 Эзэмшигчдийн өмчийн хэмжээнд өөрчлөлт оруулах
 - 6.4.10 Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах
 - 6.4.11 Сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх
 - 6.4.12 Уул, уурхайн ашиглалт, хайгуулийн лиценз шилжүүлэх, шилжүүлэн авах
 - 6.4.13 Банкнаас зээл авах, баталгаа гаргах, үндсэн хөрөнгө барьцаалах
- 6.5 ТУЗ, УЗ, ХШЗ-ийн хурлаар асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргахад терийн өмчийн төлөөлөгчид биечлэн оролцно.
- 6.6 Терийн өмчийн төлөөллийн бүрэлдэхүүн нь авсан удирдамжийн биелэлтийг хурал хуралдсанаас хойш ажлын 7 хоногийн дотор ТӨҮХГ-т ирүүлнэ
- 6.7 Терийн өмчийн төлөөлөгч нь дараахь асуудлаар тогтмол хийнхэн тавина.

- 6.7.1 Териийн өмчийн эзэмшлийн хувь хэмжээнд
- 6.7.2 Териийн өмчийн хувьцааны ногдол аштийн төлөлтийн байдалд
- 6.7.3 Эзэмшигчийн өмчийн өөрчлөлтийг тооллого, тооцоо, санхүүгийн баримтад тусгаж байгаа эсэх
- 6.7.4 Хуулийн этгээдийн дүрэмд орсон аливаа өөрчлөлтэд
- 6.7.5 Хэлэлцэж байгаа аливаа асуудлаар сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх сонирхолын бүлэг байгаа эсэх
- 6.7.6 Гадаад томилолтын удирдамж, төсөв, гүйцэтгэлд хяналт тавих

- 6.8 Териийн өмчийн төлөөллийн бүрэлдэхүүн нь тухайн хуулийн этгээдийн эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалт, захиран зарцуулалтад хагас, бүтэн жилээр дүгнэлт өгч, ТӨҮХГ-т ирүүлнэ.
- 6.9 Териийн өмчийн төлөөллийн бүрэлдэхүүн нь териийн өмчит болон териийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйлдвэрлэл, санхүү бизнесийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалт хийлгэх саналаа Санхүү хяналтын байгууллага болон ТӨХБХЗГ-т ирүүлж болно.
- 6.10 ТӨҮХГ нь териийн өмчийн төлөөллийн бүрэлдэхүүний ажлын тайлан, төлөөлөл хэрэгжүүлсэн байдлыг хагас, бүтэн жилээр дүгнэж Хорооны хуралд оруулан дүгнэлт гаргуулна.
- 6.11 ХШЗ-ийн гишүүн нь ТӨХ-ны хуралдаанаас өгсөн удирдамжийн дагуу аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалт хийх ба биелэлтийг Хорооны хуралд тайлагнана.
- 6.12 Териийн өмчийн төлөөллийн бүрэлдхүүн нь шаардлагатай гэж үзвэл териийн өмчит болон териийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлаар судалгаа, холбогдох материалыг гаргуулан авах эрхтэй.

**Долоо, Захирал, гүйцэтгэх захиралтай
үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх**

- 7.1 Териийн өмч давамгайлсан хувьцаат компанийн гүйцэтгэх захирлаар томилуулах буюу өөрчлөхөөр ТҮЗ-д оруулах саналыг судлан ТӨХ-ны хурлаар шийдвэрлүүлэх ажлыг ТӨҮХГ зохион байгуулна.
- 7.2 Териийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирлаар томилогдсон иргэнтэй ТҮЗ нь үр дүнгийн гэрээ байгуулна. Гэрээний үлгэрчилсэн загварыг Хорооны хурлаар батална. Энэ гэрээний хавсралт болох зорилтот түвшинг хуулийн этгээд нэг бүрээр Хорооны хурлаар хэлэлцэн ТҮЗ-д санал оруулна.
- 7.3 Териийн өмчит хуулийн этгээдийн захирлыг ТӨХ-ны хуралдаанаар томилох буюу өөрчлөх ба зорилтот түвшингийн үзүүлэлтүүдийг Хорооны хурлаар хэлэлцэн батална. Захирал нь ТӨХ-ны даргатай үр дүнгийн гэрээ байгуулна.
- 7.4 Гэрээний хавсралтаар үйлдвэрлэл, үйлчилгээ, санхүү эдийн засгийн үндсэн ба шалгуур үзүүлэлтээр хүрэх зорилтот түвшинг батална. Эдгээр үзүүлэлтүүд нь жилээс жилд чанаржих, аливаа неөц бүтээмжийг ашиглахад чиглэгдэнэ.
- 7.5 ТӨХ-ноос баталсан зорилтот түвшингийн үзүүлэлтүүдийг хангахаар тооцож боловсруулсан бизнес төлөвлөгөөг ТҮЗ, УЗ батална.

- 11
- 7.6 Гэрээний хугацааг ТӨҮХГ-аас өгсөн чиглэлийн дагуу тогтоох багаад зорилтот түвшинг хэтийн ба тайлант хугацааны ялгавартай тогтооно.
- 7.7 Зорилтот түвшингийн үзүүлэлтүүдийг зөвхөн ТӨХ-ны хурлын шийдвэрээр өөрчилж болно.
- 7.8 Захирал, гүйцэтгэх захирал нь ТУЗ, УЗ-ийн хуралд улирал бүр, шаардлагатай гэж үзвэл сар бүр бизнес үйл ажиллагааны талаар мэдээлэл хийнэ.
- 7.9 Захирал, гүйцэтгэх захирал нь компанийн үйл ажиллагааны тайланг ТӨХ-нд гаргаж ирүүлэх үүрэг хүлээнэ.
- 7.10 Териин өмчийн оролцостой хуулийн этгээдийн жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцэл, аудитын дүгнэлт, үр дүнгийн гэрээний биелэлтийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн дүгнэлт өгч, гүйцэтгэх захиралд олгох урамшуулал, эсвэл хүлээлгэх хариуцлагын талаар санаалаа ТӨХ-ны хуралд оруулна.
- 7.11 Териин өмчит үйлдвэрийн газрын жилийн эцсийн ажлын үр дүнгээр Захиралд олгох урамшуулалын хэмжээ, хүлээлгэх хариуцлагын талаарх саналыг ТӨҮХГ-аас боловсруулан ТӨХ-ны хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.
- 7.12 Териин өмчит хуулийн этгээдийн захирлын эрхийг түр хугацаагаар түдгэлзүүлэх асуудлыг ТӨХ-ны хуралдаанаар шийдвэрлэнэ. Териин өмчийн оролцостой хуулийн этгээдийн Гүйцэтгэх захирлын эрхийг түр хугацаагаар түдгэлзүүлэх асуудлыг ТӨХ териин өмчийн төлөвлөвөрөө дамжуулан ТУЗ, УЗ-д тавьж шийдвэрлүүлнэ.
- 7.13 "Компанийн тухай хууль"-ийн 95 дугаар зүйлд заасан бүх баримтын нэг хувийг териин өмчийн төлөөллийн бүрэлдэхүүний уг асуудлыг хариуцсан төлөвлөгөч ТӨҮХГ-т тухай бүр нь хүлээлгэн өгнө. Энэхүү баримт бичгийг ТӨҮХГ-ын салбар хариуцсан мэргэжилтэн эмх цэгтэй хадгалж албан хэрэгцээнд ашиглана.

**Найм. Үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх,
үнэлгээ дүгнэлт өгөх, хяналт шалгалт хийх**

- 8.1 ТӨҮХГ нь териин өмчит болон териийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тайлан тэнцэл, мэдээ, судалгаанд үндэслэн тэдгээрийн менежментийн байдал үйлдвэрлэл, техник технологи, здийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, тесвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлтэд хагас бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлэлт дүгнэлт өгч, авч хэрэлжүүлэх арга хэмжээний тесел боловсруулан Хорооны хуралд оруулан шийдвэрлүүлнэ.
- 8.2 Шаардлагатай тохиолдолд уг асуудлаар териийн өмчит болон териийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захирлын сонгол, мэдээллийг Хорооны хурлаар хэлэлцүүлж үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгүүлэх ажлыг ТӨҮХГ зохион байгуулна.
- 8.3 ТӨХ нь териийн өмчит болон териийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны талаарх үнэн зөв мэдээллээр УИХ, Засгийн газар териийн захиргааны төв байгууллагуудыг хангана

- 8.4 ТӨХ нь териийн өмчит болон териийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд холбогдох яам, газартай хамтран хяналт шалгалт хийнэ.
- 8.5 Териийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад ТӨХБХЗГ, Хянан шалгагчтай хамтран шалгалт хийж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулна. Шаардлагатай тохиолдолд асуудлыг хууль, хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.
- 8.6 Териийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгийн азэмшилт, захиран зарцуулалтад тавих хяналтыг "Териийн болон орон нутгийн өмчийн тухай" хууль, компанийн дүрмээр зохицуулах ба компанийн санхүүгийн үйл ажиллагаанд ХШЗ хяналт шалгалт хийнэ.
- 8.7 Териийн өмчит үйлдвэрийн газрын эд хөрөнгийн азэмшилт, ашиглалт, захиран захирцуулалтад ТӨХБХЗГ системийн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх ба аж ахуй санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх хувь аарийг ТӨХ баталж мөрденэ. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын байдлыг харгалзан түүнийг арилгуулах хугацаатай үүрэг өгч, шаардлагатай бол Захирал, гүйцэтгэх захиралд хариуцлага ногдуулна.
- 8.8 Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалыг шаардлагатай гэж үзвэл шүүх, хуулийн холбогдох байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлнэ.
- 8.9 Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах талаар гарсан шийдвэрийн биелэлтэд гүйцэтгэлийн хяналтыг ТӨХБХЗГ хэрэгжүүлнэ.
- 8.10 Шалгалтын талаарх мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэголзэр олон нийтэд мэдээлэх ажлыг ТӨХ-ны Захиргаа, удирдлагын газар зохион байгуулна.

Ес. Териийн өмчийн төлөөллийг шилжүүлэх

- 9.1 Териийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн териийн мэдлийн хувьцааг худалдан авч, Монголын хөрөнгийн биржээр гүйлгээ хийлгэн, багц хувьцаагаа өөрийн нэр дээр шилжүүлсэн иргэн, хуулийн этгээдад тухайн компанийн удирдлагыг ТӨХ-ны шийдвэрээр дараах байдлаар шилжүүлнэ.
- 9.1.1 Дуудлагын худалдааны ялагч иргэн, хуулийн этгээд нь тухайн компанийн териийн мэдлийн хувьцаанаас худалдаж авсан хэмжээгээр эрх эдлэж, үүрэг хариуцлага хүлээнэ.
- 9.1.2 Компанийн ТҮЗ, ХШЗ-ийн бүрэлдэхүүнээс териийн мэдлээс худалдсан хувьцааны хэмжээтэй хувь тэнцүүлэн териийн өмчийн төлөөллийн гишүүдийг чөлөөлнэ.
- 9.1.3 Териийн өмчийн төлөөллөөс чөлөөлөгдсөн гишүүдийн тоогоор ТҮЗ, ХШЗ-ийн хуралд таслах эрхтэй оролцох итгэмжлэлийг шинэ өмчлөгчид олгоно.
- 9.1.4 Итгэмжлэлийг Хувь нийлүүлэгчдийн хурал хуралдуулах хүртэл хугацаагаар олгох ба хугацаа нь 3 сараас дээш байж болохгүй.
- 9.2 Териийн өмчит үйлдвэрийн газрын захирал нэг сараас дээш хугацаагаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолцолд

шазардлагатай гэж үзвэл ТӨХ итгэмжлэгдсэн төлөөлөгч томилон тодорхой хугацаагаар ажиллуулж болно.

- 9.3 Төрийн өмч давамгайлсан хувьцаат компанийн гүйцэтгэх захирал нэг сараас дээш хугацаагаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд ТӨХ-ноос төрийн өмчийн төлөөлөгчийн аль нэгийг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилон өмч хөрөнгийн захиран зарцуулалтад хяналт тавьж болно.
- 9.4 Энэ журмын 9.2, 9.3-д заасан итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх, үүрэг, хариуцлагыг ТӨХ тухай бүр тогтооно.

Арав. Хориглох зүйл

- 10.1 Төрийн өмчийн төлөөлж Хувь нийлүүлэгчдийн хуралд таслах эрхтэй оролцох итгэмжлэлтэй төрийн өмчийн төлөөлөгчөөс бусад төрийн өмчийн төлөөлөгчид хуралд таслах эрхтэй оролцохыг хориглоно.
- 10.2 Төрийн өмчийн төлөөлөгч нь тухайн компанийн аль нэгэн эрх бүхий албан тушаалтны эхнэр, нөхөр, эцэг, эх, хүүхэд, ах, эгч, дүү болон бусад ойрын төрөл байвал ТӨҮХГ-т мэдэгдэж өөрийн хүсэлтээр чөлөөлөгднө.
- 10.3 Төрийн өмчийн төлөөлөгч нь хувийн өмчлөгчдөөс сонгогдсон ТУЗ, ХШЗ-ийн пишүүний ойрын төрөл байх буюу нэгдмэл сонирхолтой байж болохгүй.
- 10.4 Төрийн өмчийн төлөөлөгч нь асуудалд хувийн ашиг сонирхалтын үүднээс хандахыг хориглоно.
- 10.5 Төрийн өмчийн төлөөлөгч нь төлөөлөл хэрэгжүүлж буй хуулийн этгээдэд болон түүний эрх бүхий албан тушаалтанд өр, телбэртэй байж болохгүй.

Арван нэг. Хариуцлага

- 11.1 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тухайн сард ТУЗ, УЗ-ийн хуралд биечлэн оролцоогүй, төрийн өмчийн төлөөлөгчийн үүрэгтэй холбогдсон ажил үүрэг гүйцэтгэгүй тохиолдолд тухайн сард ногдох хөлсийг олгохгүй. Хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүй дараалан З ба түүнээс дээш удаа оролцоогүй төрийн өмчийн төлөөлөгчийг өөрчлөх асуудлыг ТӨҮХГ нь Хорооны хуралд оруулж шийдвэрлүүлнэ.
- 11.2 Төрийн өмчийн хорооноос өгсөн удирдамж, заавар энэхүү журмыг хүндэтгэх шалтгаангүйгээр зөрчсөн буюу удирдамжийн эсрэг санал өгсөн бол төрийн өмчийн төлөөлөгчийг томилсон шийдвэрийг хүчингүй болгож, түүнийг өөрчилнэ.
- 11.3 ТӨХ-ноос баталсан удирдамжийн дагуу ТУЗ, УЗ шийдвэр гаргаснаас үүсэх үр дагаварыг төрийн өмчийн төлөөлөгч хариуцахгүй.
- 11.4 Төрийн өмчийн төлөөлөгч нь Хувь нийлүүлэгчдийн болон ТУЗ, УЗ, ХШЗ-ийн хуралд удирдамжгүйгээр оролцож хурлаас гаргасан шийдвэр нь хууль тогтоомж зөрчсөн, компанийд хохирол учруулсан бол ТӨХ шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

- 11.5 Төрийн өмчийн төлөөлөгч нь энэхүү журам, хууль тогтоомж зөрчсөн нехцелд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Арван хоёр . Бусад

- 12.1 Орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэхдээ энэ журмыг арга зүй болгон хэрэглэж болно.
- 12.2 Энэ журмыг 2005 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс дагаж мөрдөнө.

----- 0 0 0 -----